



ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2026 оны 06 сарын 29 өдөр

Дугаар А/56

Баян-Өндөр сум

┌ Эм, эмнэлгийн хэрэгсэл хуваарилах тухай ┐

Монгол Улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 4.2 дугаар зүйлийн 4.2.1, 16.16, 20.1.6 дахь заалт, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль, Эрүүл мэндийн сайдын 2024 оны "Журам, заавар батлах тухай" А/18 дугаар тушаалын 3.1.7 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын 2019 оны "Эхээс хүүхдэд ХДХВ, гепатитын В вирус болон тэмбүүгийн халдвар дамжихыг зогсоох журам" батлах тухай А/614 тоот тушаалын 4.5 дахь заалт, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн 2026 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн А/181 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, сүрьеэгийн төслийн Өр хөврүүлэх нэмэлт санхүүжилтийн хүрээнд ханган нийлүүлэгдэж байгаа гепатитын В вирусийн халдвартай жирэмсэн эхчүүдэд зориулсан вирусийн эсрэг үйлчилгээтэй ТенофOVER 300 мг эмийг Орхон аймгийн Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Эм зүйн тасагт олгох хуваарийг нэгдүгээр, эмийн зарцуулалтын сар бүрийн мэдээний маягтыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Эмийг зорилтод бүлэгт олгож, эмчилгээ үр дүнд хяналт тавихыг Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн захирал (Ц.Наран-Эрдэнэ), олголт, зарцуулалтад хяналт тавьж ажиллахыг Эмийн бодлогын хэрэгжилт, оношилгоо эмчилгээний технологи хариуцсан мэргэжилтэн (О.Анхбаяр), хавсралтын дагуу Эрүүл мэндийн байгууллагуудад олгох, анхан шатны бүртгэлийг бүртгэлжүүлэн ажиллахыг Эрүүл мэндийн газрын нярав (Б.Алтанзагас) нарт тус тус үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Удирдлага төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн (Б.Уртнасан)-д даалгасугай.

ДАРГА



Ц.МӨНХЦЭЦЭГ

Орхон аймгийн Эрүүл мэндийн газрын 2026 оны .06. сарын
.29. өдрийн 1/58 тоот тушаалын нэгдүгээр хавсралт



БОЭТ-ийн Эм зүйн тасагт тенофOVER эмийг

олгох хуваарь

2026-06-26

№	Бараа материал, савлалт	Код	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Tenofovir Disoproxil Fumarate 300 mg	08795	хайрцаг	50	7,884.55	394,2276.50

Хуваарь гаргасан: ЭМГ-ын НЭМТҮБТХАМэргэжилтэн *Н.Мөнгөнцацралт* Н.Мөнгөнцацралт

Хянасан: ЭМГ-ын ССМНББХАжилтан *Г.Отгонцэцэг* Г.Отгонцэцэг

газрын 2026 оны 06... са
аалын хоёрдугаар хавср

Байгууллагын нэр:

....сарын мэдээ

[illegible]

Мэдээ гаргасан:

Албан тушаалтны нэр

Байгууллагын нэр

...сарын мэдээ

[illegible]